



ЭХЭ

**БАГГИЙН
ТУЛААН**

**ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**

2023.5.13.14

**ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН
“БАГИЙН ТУЛААНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2023”
ЗААВАР**

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчилах,
- Тамирчдын багаар ажиллах чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	Монголын Таеквондогийн Холбоо
Холбоо барих	8010-0471 (Бүртгэл)
E-mail	mongoliatekwondo@gmail.com
Facebook хуудас	www.facebook.com/mongoliatekwondo/

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Өдөр	Хөтөлбөр	Байршил
05.03-05.08-ний өдөр хүртэл	<ul style="list-style-type: none">• Бүртгэл• 05 сарын 08-ны 18:00 цагт бүртгэл хаагдана	www.mongol-taekwondo.com
05.12-ны өдөр	<ul style="list-style-type: none">• Техникийн зөвлөгөөн, сугалаа	Үндэсний шигшээ багийн заал
05.13-14-ний өдрүүдэд	<ul style="list-style-type: none">• Тэмцээн	Зайсан Фанк Хаус эвент холл

Жич: Бүртгэл хаагдсаны тулааны хуваарь нийтэд зарлагдах ба багууд тулалдах хуваарьт өдрийн өглөө нь жингээ үзүүлнэ.

ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

1) ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД БАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Тэмцээнд оролцогч тамирчин нь Күккивоны хар бүс, Монголын таеквондогийн холбооноос олгосон гүп зэргийн бүстэй байж болно. /Бүсний ангилалгүй/
- Монголын таеквондогийн холбоотой гэрээтэй, албан ёсны гишүүн байгууллага түүний тамирчид оролцоно.
- Заасан хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй
- Тэмцээнд оролцох байгууллага нь холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.
- Тамирчин нь Монголын таеквондогийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.
- Тэмцээнд оролцогч тамирчин бүр таеквондогийн ёс, дэг журмыг чанд баримтлан, хувийн ариун цэврийг дээд зэргээр хангасан байх шаардлагатай. Үүнд: гар, хөлийн хумсыг засаж, элдэв бөгж, хүзүүний зүүлт зэргийг хэрэглэхгүй байх
- Тэмцээнд оролцогч багууд тамирчдынхаа байр, хоолыг өөрсдөө хариуцна.
- Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгой анхааруулж байна.
- Шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай.
- Тулаан Daedo цахим онооны системээр явагдана.
- Бага нас, өсвөр үеийн тамирчид тулааны үеэр нүүрний хамгаалалтын касктай тулалдах багууд нүүрний каскыг бэлдэнэ.
- Нэг клубээс оролцох багийн тоонд хязгаарлалт тавигдахгүй.
- Нэг багт үндсэн гурван тамирчин, нэг сэлгээний тамирчин буюу нийт дөрвөн тамирчин байна.
- Багууд өөрийн клубын нэрийн өмнөөс эсвэл ивээн тэтгэгч байгууллагын нэр дээрээс тулалдаж болно.
- Багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.

2. Насны ангилал ба нийлбэр жин /4 тамирчин/

Нас	Эрэгтэй баг /нийлбэр жин/	Эмэгтэй баг /нийлбэр жин/
Бага нас /8-9 нас/	124кг	120кг
Бага нас /10-11 нас/	150кг	146кг
Өсвөр үе /12-14 нас/	217кг	197кг
Залуучууд /15-17 нас/	266кг	240кг
Насанд хүрэгч /18-29 нас/	307кг	261кг
Мастер /+30 нас/	337кг	283кг

3. Тэмцээний формат

Багийн тулааны тэмцээн нь уламжлалт хэлбэрээр Daedo цахим онооны системээр явагдана.

3.1 Баг бүр тэмцээнд гарааны 3 тамирчин, 1 сэлгээний тамирчинг томилно. Тамирчдыг 1 (хамгийн хөнгөн) - 4 (хамгийн хүнд) хүртэл дугаарлана.

3.2 Тэмцээнийг 3 үе шаттайгаар (1-р үе 3 минут, 2-р үе 3 минут, 3-р үе 3 минут) хооронд 1 минутын завсарлагатайгаар явагдана.

3.3. 1-р шат нь уламжлалт багийн тоглолтын хэлбэрийг үндэслэн тамирчид өөртэй нь ижил дугаар бүхий өрсөлдөгч багийн тамирчинтай таарч тус бүр 1 минут тулалдана. Энд багийн тамирчдын дугаарлалт багаас их хүртэлх дарааллаар буюу хөнгөн жингийн тамирчнаас хүнд жингийн тамирчин хүртэлх дарааллаар явагдана. Багийн тамирчин тус бүрийн авсан онооны нийлбэр нь тухайн багийн оноо болж бүртгэгдэнэ.

3.4. 2-р үед тэмцээн эхлэхээс хагас цагийн өмнө багийн дасгалжуулагчийн ирүүлсэн 3 тамирчны дарааллаар 3 минутын турш тулаан явагдана.

3.5 3-р үед 3 минутын туршид багийн дасгалжуулагчийн санал болгосон тамирчнаа ээлжлүүлэн (Tag team) тулалдуулна. Үеийн туршид тамирчдын дараалалаас үл хамааран хамгийн ихдээ 12 удаа солилцоо хийхийг зөвшөөрнө.

3.6 1, 2, 3-р үед нийлбэр оноогоор илүү оноо авсан багийг ялагчаар тодруулна. Хэрэв 3 үеийн дараа оноо тэнцсэн тохиолдолд тамирчин солилцооны зарчмаар дээд тал нь 3 минут тулалдуулна. Ингэхдээ түрүүлж 4 оноо авсан багийг ялагчаар тодруулна.

3.7 Торгуулийн нийт тоо 20 хүрсэн багийг тэмцээний аль ч үед хожигдсонд тооцно.

3.8 Багийн тулаанд онооны илт давуугаар ялалт гэсэн ойлголт байхгүй.

3.9 Найм буюу түүнээс дээш баг өрсөлдөж байгаа бол хэсгийн шатнаас шигшээ тоглолт хүртэл хасагдах системээр явуулна.

3.10 Нэг нас, хүйсний ангилалд долоо буюу түүнээс цөөн тооны баг оролцсон тохиолдолд хагас шигшээ хүртэл тойргоор өрсөлдөж хагас шигшээ, шигшээ тоглолт хасагдах системээр явагдана.

3.11 Таваас долоон баг оролцож байгаа бол санамсаргүй аргаар хоёр хэсэгт хуваагдана. Хэсэг тус бүрт багтаж буй багууд хоорондоо тойргоор тулалдаж хамгийн өндөр оноо авсан хоёр баг хагас шигшээд шалгарна.

3.12 Хэсгийн шатанд хожсон баг 3 оноо, хожигдсон бол 0 оноо авч бүх тойргийн тоглолтын дараа хамгийн өндөр оноо авсан баг хагас шигшээд шалгарна.

3.13 Хагас шигшээд хамгийн өндөр оноо авсан баг хамгийн бага оноо авсан нөгөө хэсгийн багтай учраа таарна. Оноо тэнцсэн тохиолдолд дараах зарчмыг баримтална:

- Багийн авсан онооноос эсрэг багийн авсан оноог хасаад илүү их оноо цуглуулсан баг
- Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд торгуулийн тоо багатай багийг ялсанд тооцно
- Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд тэмцээний ерөнхий шүүгч багийн оноолтыг бүрэн эрхийн хүрээнд шийднэ.

3.14 Баг бүр тулалдахаас гучин (30) минутын өмнө шалгагч шүүгчийн хэсэгт очсон байх үүрэгтэй.

3.15 Баг бүрийн оролцогцдын цээжний хамгаалалтын хэсэгт эрэмбийн тоо бүхий дугаарыг таних зорилгоор байрлуулна. Сэлгээний тамирчинд “4” гэсэн тоо өгнө.

3.16 Баг тус бүрт гурван (3) гарааны тамирчин, нэг (1) сэлгээний тамирчин, хоёр (2) дасгалжуулагч, нэг (1) багийн эмч хамт байж болно.

4. Сэлгээний тамирчин:

4.1 1-р үеийн дараа багийн гурван (3) тамирчны аль нэгийг нь нэг удаа сольж болно.

4.2 Тэмцээний үеэр багийн тамирчид бэртэл авч хамгийн багадаа гурван тамирчин бүхий бүтэн багаар өрсөлдөх боломжгүй болсон тохиолдолд тухайн багийг хожигдсонд тооцно.

5. Шигшээ багийн тамирчдын хуваарьлалт

Тэгш өрсөлдөөний зарчмын үүднээс шигшээ багт харъяалагддаг тамирчдыг нэг багт хамт оруулахгүй ба насанд хүрэгчдийн эрэгтэй багийн хувьд дараах зохицуулалт үйлчилнэ.

- Насанд хүрэгчдийн эрэгтэй багийн тамирчдын бүртгэлийг багаар бус хувь тамирчнаар бүртгэнэ.
- Тамирчин нь хувь тамирчнаар бүртгэлээ хийлгэх ба нийт бүртгэгдсэн тамирчдыг санамсаргүй аргаар сугалаа хийж баг бүрдүүлэлт хийнэ.
- Тамирчин бүртгүүлэхдээ дараах жингээс өөрийн оролцох жингийн сонголтыг хийнэ. - 58кг, -63кг, -68кг, -74кг

6. Оролцогчийн ХУРААМЖ

Тэмцээнд оролцогч нэг багийн дэвжээний төлбөр

- Улаанбаатар хотын баг дэвжээний төлбөр 600.000 (зургаан зуун мянга)-н төгрөг

Хөдөө, орон нутгийн тамирчид

- Улаанбаатар хотоос 1000 км дотогш 400.000 (дөрвөн зуун мянга)-н төгрөг,
- Улаанбаатар хотоос 1000 км гадагш 300.000 (гурван зуун мянга)-н төгрөг

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Хаан банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

7. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Насны ангилал бүрт эхний 3 байр эзэлсэн багийн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.
- Нас насны ангилалд түрүүлсэн багт Улсын аваргын цом, мөнгөн шагнал дагалдана.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -